



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 5 дугаар
сарын 2-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар
хот


Жагсаалт шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.20, 9.1.21-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгож байгаа 500 (таван зуун) сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Хавсралтад заасан төслийг БНХАУ-ын Засгийн газарт санал болгож, хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн болон холбогдох сайд нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн тухай” Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

